

# GPZ 7000 загварын илрүүлэгчийн програмын 2-р шинэчлэл – GPZ илрүүлэгчийнхээ хүчин чадлыг улам сайн ашиглаарай!

**GPZ7000**

Програмын энэ шинэчлэлийн гол давуу тал нь хөрс тогтворжуулах цоо шинэ функц юм. Хагас автомат тохиргоог мөн Хөрсний тэнцвэрийн горимд нэмж оруулсан. Энэ хоёр функцийг боловсронгуй болгосноор та GPZ 7000 загварын илрүүлэгчээрээ бүр илүү олон төрлийн хөрсөнд ажиллах боломжтой боллоо.


Мөн энэ шинэчлэлийг хийснээр хятад, монгол хэлийг одоо дэмждэг болсон.

Цоо шинэ функц:

## Хөрс тогтворжуулах

Энэ функц саад бэрхшээлтэй хөрс, ялангуяа давстай хөрстэй ажиллахад тусалдаг, сонгох боломжтой шуугианы шүүлтүүрийг идэвхжүүлнэ. Хөрс тогтворжуулах шинэ функц хэд хэдэн давуу талтай.

- ✓ Давстай хөрсний шуугианы нөлөөг бууруулна
- ✓ Өмнө "хориотой" байсан талбайд илрүүлэх боломж олгоно
- ✓ Хоёр тавагтай ажиллахад гүний хэмжээг нэмэгдүүлнэ
- ✓ Таны хөрс хамрах үр дүнг нэмэгдүүлнэ



Хөрс тогтворжуулах функц Detect Plus хуудсанд бий. Хөрс тогтворжуулах функц таны илрүүлэх хэрэгцээ шаардлагад тохирсон гурван тохиргоотой.

**Идэвхгүй (өгөгдмөл)**  
Энэ бол GPZ 7000 загварын илрүүлэгчийн анхны тохиргоо юм.

**Газар олох**  
Энэ тохиргоо нь илүү их хөрс хамрах боломжийг танд олгоно. Та үр бүтээлтэй самнаж байх зуур шаардлагагүй шуугианыг бууруулна.

**Давстай хөрс**  
Энэ нь урьд өмнө хориотой байсан давстай (хэт шүлтлэг, дамжуулах чадвартай) хөрсөнд ажиллах боломжийг танд олгоно. Илрүүлэх гүний хэмжээнд нөлөөлж болох тул зөвхөн тухайн хөрсөнд шаардлагатай үед үүнийг ашиглах хэрэгтэй.

## Та амжилттай олж илрүүлэхийн тулд зөв таваг сонгож ашиглана уу

Хөрс тогтворжуулах функц бүр, янз бүрийн төрлийн хөрстэй хослуулж ажиллах үед GPZ 14 загварын таваг бол GPZ 19 нэмэлт тоноглолын таваг харилцан адилгүй түвшинд ажиллаж илрүүлдэг.

Хүснэгтэд үзүүлснээр GPZ 19 загварын таваг бол харьцангуй зөөлөн хөрстэй нөхцөлд удаан илрүүлэхэд маш сайн тохирдог бол GPZ 14 загварын таваг давстай хөрсөнд оновчтой илрүүлэхэд илүү тохирно.



	GPZ14	GPZ19
Идэвхгүй	Өгөгдмөл ажиллагаа	Гүнд илрүүлэх
Газар олох	Хөрс хамрах байдал	Хөрс хамрах байдал
Давстай хөрс	Зохистой	Зохисгүй



Хөрс тогтворжуулах талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл [www.minelab.com/go-minelabbing/treasure-talk](http://www.minelab.com/go-minelabbing/treasure-talk) вэбсайт дахь Эрдэнэсийн тухай яриа блогт зочилно уу.

## Манай хээрийн туршигч нар юу ярьсныг сонсьё...

"Газар олох тохиргоог хийснээр одоо маш "халуун" латерит хөрсөнд Хэвийн хөрс төрлийг ашиглах боломжтой боллоо!"

1 дэх хээрийн туршигч – Келгурли хот, БА



"Эдгээр шинэ тохиргоо бол нэг төрлийн зэвсэг юм... Би Их олдвор/Энгийн горимд ажиллаж болох бөгөөд объект таны нүдний өмнө шууд гарч ирнэ."

2 дахь хээрийн туршигч – Мериборо хот, ВИКТОРИА



"Гол ашиг тус нь давслаг/давстай хөрсөнд ажиллахад гарч ирнэ. Хөрс муу байх тусам шинэ тохиргооны ашиг тус улам их гарч ирнэ."

3 дахь хээрийн туршигч – Клермонт хот, КВИНСЛЕНД



"Виктория муж руу явж, ½ унц хэмжээтэй цул алт олсон шүү! Объект маш тод сонсогдож байсан бөгөөд аль нь шуугиан, аль нь объект болохыг ялахад илүү амар хялбар байв."

4 дэх хээрийн туршигч – Аделэйд хот, ЗА



ZVT Super-D GPSi Wi-Stream  
World's Best Metal Detection Technologies

**MINELAB**




Хайлтын тэнцвэрийн горим бүхий шинэ тохиргоо:

## Хагас автомат

Энэ шинэчлэл Хайлтын тэнцвэрийн горимд Хагас автомат тохиргоог нэмж оруулж байна. Хагас автомат тохиргоо танд дараах ашиг тус өгнө.

- ✓ Мэргэшсэн хэрэглэгчдийн хувьд илүү сайн удирдаж ажиллуулах, уян хатан байх
- ✓ Хайлтын тэнцвэрийн тогтвортой байдлыг улам сайжруулах
- ✓ Илрүүлэхэд ярвигтай нөхцөлд ажиллах өөр нэгэн арга зам
- ✓ Мэргэшсэн хайгуулчдын хувьд мэргэжлийн багаж хэрэгсэл



Хайлтын тэнцвэрийн горимын функц Detect Plus хуудсанд бий. Хайлтын тэнцвэрийн горимын функц таны илрүүлэх хэрэгцээ шаардлагад тохирсон гурван тохиргоотой.

Бүх горимд ферритыг заавал газар тавьж, Quick-Trak функцийг идэвхжүүлэх шаардлагатай.



### Автомат (Өгөгдмөл)



Тогтвортой байлгаж, илрүүлэх гүний хэмжээг тогтоон барихын тулд Автомат хөрсний тэнцвэр хөрсний эрдэсжилтийг автоматаар хянаж, хөрсний тэнцвэрийг зохих ёсоор тохируулдаг.

Автомат бол Хайлтын тэнцвэрийн горимд зориулсан зохистой тохиргоо мөн.

Автомат горимд асаасны дараа эсвэл тохиргоог өөрчилсний дараа хэвийн илрүүлж эхэлснээс хойш 10-аас 15 секундийн дотор хайлтын тэнцвэр автоматаар тогтворжино. Эсвэл автоматаар тэнцвэржүүлэх процессыг хурдавчлахын тулд Quick-Trak функцийг ашиглаж болно.

### Хагас автомат



Хагас автомат горимд илрүүлэх явцад Хайлтын тэнцвэрийг автоматаар тохируулах боловч Quick-Trak функцийг гараар идэвхжүүлэх ёстой. Автомат горимтой адил автоматаар хайлтыг тэнцвэржүүлэх процессыг хурдавчлахын тулд шар ферриттэй Quick-Trak функцийг ашиглах боломжтой.

Энэ горимд феррит бүрэлдэхүүн хэсгийн тэнцвэрийг хэрэглэгчийн хүссэн түвшинд тохируулна. Зөвхөн гараар Quick-Trak функцийг идэвхжүүлэх замаар үүнийг өөрчлөх боломжтой.

Энэ горимд шар ферритыг заавал газар тавьж, хайлтыг тэнцвэржүүлэх шаардлагатай.

### Гараар



Гараар хайлтыг тэнцвэржүүлэх горимд тохируулсан үед илрүүлэгч автоматаар хөрсийг мөрдөхгүй. Гараар тохируулах горимыг ашиглахдаа та хөрсний тэнцвэрийг нарийн барихын тулд Quick-Trak функцийг тогтмол идэвхжүүлэх ёстой.

Энэ горимд шар ферритыг ашиглаж, хайлтыг тэнцвэржүүлэх нь тун зүйтэй.


## Техникийн тайлбар

Металл илрүүлэгч хүлээн авсан дохиог Хайлтын тэнцвэрийн (ХТ) хоёр үндсэн бүрэлдэхүүн хэсэг болгож хуваана. ферритын бүрэлдэхүүн хэсэг (Х), хөрсний бүрэлдэхүүн хэсэг (G). Үүний дараа сонсогдох боломжтой хамгийн тод дохиог хэрэглэгчид өгөхийн тулд бүрэлдэхүүн хэсэг тус бүрийг боловсруулдаг.

Тус диаграм Хайлтын тэнцвэрийн горим бүр хөрсний хоёр бүрэлдэхүүн хэсгийг хэрхэн боловсруулдаг болохыг харуулна.

**Автомат:** 100% мөрдөх ХТ, 0% байнгын ХТ-тэй дүйнэ.


Автомат горим хөрс, феррит хөрсний бүрэлдэхүүн хэсгийг хоёуланг тасралтгүй хянаж, илүү тогтвортой авиа, улам тод дохио сонсогдоход хүргэх ёстой.



Автомат бол зохистой горим мөн бөгөөд ихэнх нөхцөлд хамгийн сайн үр дүн өгөх ёстой.

**Хагас автомат:** 80% мөрдөх ХТ, 20% байнгын ХТ-тэй дүйнэ.


Хагас автомат горим феррит хөрс бүхий бүрэлдэхүүн хэсгийн мөрдөх ажиллагааг тохируулах боловч хөрсний бүрэлдэхүүн хэсгийг автоматаар хянана.



Хагас автомат горим туршлагатай хэрэглэгчдэд хэрэгтэй зүйл мөн. Хагас автомат горим G-г үргэлжлүүлэн хянахын зэрэгцээ X-ийг тохируулж, бага зэргийн бүдэг дуу авиа сонсогдохыг зогсоож, илүү тогтвортой харуу өгч болно.

**Гараар:** 0% мөрдөх ХТ, 100% байнгын ХТ-тэй дүйнэ.

Гараар тохируулах горим хөрс, феррит бүрэлдэхүүн хэсгийн байнгын мөрдөлттэй байдаг тул бүх хайлтын тэнцвэрийг гараар тохируулах ёстой.



Хэрэглэгч GPZ 7000 загварын илрүүлэгчийг ажиллуулж сайн мэддэггүй бөгөөд хөрсний нөхцөл тогтвортой бус маш өөрчлөгдөмтгий бол гараар тохируулах нь зохисгүй.

----- Янз бүрийн хөрсний төлөөлөл      — Феррит (Х) мөрдөх      — Хөрс (G) мөрдөх



“Хагас автомат горимд GPZ загварын илрүүлэгчээр хөрсөн дээгүүр самнахад бүх горим, ялангуяа Хэвийн хөрсний төрөл бүхий горимд илт чимээгүй ажилладаг.”

З дахь хээрийн туршигч – Клермонт хот, Квинсленд



## Шинээр нэмэгдсэн хэл

ШИНЭ!



中文




МОНГОЛ

GPZ 7000 загварын илрүүлэгчийн хэрэглэгчийн интерфэйсийг одоо хятад, монгол хэлээр харуулах боломжтой болсон.

Эдгээр шинэ хэлийг анх ажиллуулж эхлэхэд идэвхжүүлж болно.

Эдгээрийг мөн Шинээр тохируулах хуудсанд буй Хэлний функцээр дамжуулан сонгож болно.



Хятад, монгол хэлээр GPZ 7000 загварын илрүүлэгчийн гарын авлагыг татаж авахын тулд [www.minelab.com](http://www.minelab.com) вэбсайтад зочилно уу.

## Засвар үйлчилгээний төв эсвэл борлуулагчаар шинэчлүүлэх

Илрүүлэгчийн тохойвчийн доорх удирдлагын блок, бариулын дээрх хэрэглэгчийн интерфэйсийг хооронд нь холбож, хосоор нь шинэчлэх ёстой.

Тиймээс хэрэв та энэ шинэчлэлийг хийлгэхээр илрүүлэгчээ борлуулагч эсвэл засвар үйлчилгээний төв рүү илгээх бол удирдлагын блок, бариул/хянах самбарыг авчраарай.

## XChange 2 програмтай тохирч ажиллах эсэх

Энэ шинэчлэл одоогоор XChange 2 програмтай тохирч ажиллахгүй тул XChange 2 програмыг GPZ 7000 загварын илрүүлэгч дээр ажиллуулах боломжгүй болгоно.

XChange 2 програмын тохирч ажиллах боломжтой хувилбар цаашид гарах бөгөөд тэр үеэр бүрэн тохирч ажиллах боломж бүрдэнэ. Таныг GPZ шинэчлэлийг хийхэд эсвэл XChange 2 програмын энэ шинэ хувилбар гарч ирэхэд XChange 2 програмд таны хадгалсан аливаа өгөгдөл алдагдахгүй.




## GPZ 7000 загварын илрүүлэгчийг шинэчлэх дараалал

Доорх үйлдлийг гүйцэтгэн GPZ 7000 загварын илрүүлэгчийн ҮНЭГҮЙ програмыг татан авч суулгана уу.

GPZ 7000 загварын илрүүлэгчээ засвар үйлчилгээний төвд авчрах ямар ч шаардлагагүй!



### Шинэчлэлийг татан авч шилжүүлэх:



**ЧУХАЛ:**

Шинэчлэхийн өмнө зайг бүрэн цэнэглэнэ үү.

Шинэчлэх явцад хэдийд ч илрүүлэгчийг унтрааж болохгүй. Эс бөгөөс шинэчлэгдэхгүй.

#### 1. Програмыг шинэчлэх файлыг татан авах

[www.minelab.com/gpz7000](http://www.minelab.com/gpz7000) вэбсайтад зочилж, 'Downloads' гэсэн хэсэг дээр товшино уу.


"Програмын шинэчлэл (Илрүүлэгчийн програм)" гэсэн хэсэг дэх GPZ 7000 загварын илрүүлэгчийн програмын шинэчлэл дээр товшиж, татан авч эхэлнэ үү. Автоматаар таны компьютерт хадгалагдах болно.

#### 2. GPZ 7000 загварын илрүүлэгчийг компьютертой холбох

GPZ 7000 загварын илрүүлэгчээ компьютертой USB кабелиар холбоно уу.

'Minelab' гэсэн нэртэй драйв гарч ирнэ.

#### Devices with Removable Storage



#### 3. Програмыг шинэчлэх файлыг дамжуулах

'Minelab' драйвыг нээж, програмыг шинэчлэх файлыг тийш нь хуулна уу. Файлыг дамжуулсны дараа доорх 'Install the Update' хэсэгт очно уу.

### Шинэчлэлийг суулгах:

#### 1. Илрүүлэгчийг компьютероос салгах


Програмын шинэчлэх файлыг илрүүлэгчид дамжуулсны дараа драйвыг гаргах замаар компьютерээс салгаж, дараа нь USB кабелиг салгаж авна уу.

GPZ 7000 загварын илрүүлэгчийн дэлгэцэд 'USB Disconnected' гэсэн бичиг гарч ирнэ. Энэ бичиг дэлгэцэд 2 минут хүртэл харагдаж болно.



#### 2. GPZ 7000 илрүүлэгчийн програмыг шинэчлэх


Одоо хэрэв шинэчлэх файлыг олсон бол дараах цонх харагдана.



Програмыг шинэчилж эхлэхийн тулд 'Upgrade' гэснийг сонгоно уу.

**Анхаар:** Хэрэв та **Цуцлах гэж сонговол** таны дамжуулсан програмыг шинэчлэх файл шууд устана. Та програмыг шинэчлэх файлыг суулгахын тулд үүнийг дахин дамжуулах хэрэгтэй.

Шинэчлэх явц харагдах болно.



#### 3. Шинэчилж дуусах

Шинэчилж дуусахад GPZ 7000 загварын илрүүлэгч өөрөө унтарна. Таныг дахин асаахад илрүүлэгч шинэ програмаар ажиллаж эхэлнэ.



Та Шинээр тохируулах хуудсанд буй Хувилбарын мэдээллийн функцээр дамжуулан илрүүлэгчийнхээ програмын мэдээллийг хэдийд ч шалгаж болно.

Хэрэв энэ шинэчлэлийг амжилттай суулгасан бол дараах хувилбарын мэдээлэл харагдана.

Хянах самбар: 1.10.8-2052

Удирдлагын блок: 2.4.4-127

**Шинэчлэл амжилтгүй болох:** Хэрэв шинэчлэхэд танд ямар нэг хүндрэл бэрхшээл гарвал эхнээс нь дуустал дараах шинэчлэх үйлдлийг хийхийг оролдож үзээрэй. Хэрэв ингээд болохгүй бол та борлуулагч эсвэл Minelab компанийн засварын төвтэй холбоо барина уу.



We Change People's Fortunes

**Minelab Electronics XXX.**

Австрали улс, Номхон Далайн орнууд

+61 8 8238 0888

minelab@minelab.com.au

**Minelab Americas Инк.**

Хойд, Өмнөд болон Төв Америк

+1 630 401 8150

info@minelabamericas.com

**Minelab International XXX.**

Европ, Орос улс

+353 21 423 2352

minelab@minelab.ie

**Minelab MEA General Trading XXX**

Ойрх Дорнод, Африк

+971 4 254 9995

minelab@minelab.ae

